

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ”
ХХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2026 оны 03 сарын 23
өдрийн 26/21 тоот тогтоолын
Хавсралт № 7



SOLOMON INVESTMENTS

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

Баримт бичгийн төрөл/ Type:	Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам
Хамрах хүрээ/ Area:	“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ” ХХК-ийн ажилтнуудад
Нууцын зэрэглэл/ Confidentiality:	Дотоодод нээлттэй
Баримт бичгийн дугаар/Number:	... м. / 26 / 35
Боловсруулсан/ Prepared by:	Төлөөлөн удирдах зөвлөл
Баталсан/ Approved by:	“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл
Хуудасны тоо/ Page number:	9 хуудас
Хянан нийцүүлэх давтамж:	Жилд 1 удаа
Батлагдсан огноо/ Effective date:	2026 оны 03 сарын 23

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ”
ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны ... сарын ... өдрийн
.....тоот тогтоолын Хавсралт№...



SOLOMON INVESTMENTS

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

Баримт бичгийн төрөл/ Type:	Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам
Хамрах хүрээ/ Area:	“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ” ХХК-ийн ажилтнуудад
Нууцын зэрэглэл/ Confidentiality:	Дотоодод нээлттэй
Баримт бичгийн дугаар/Number:
Боловсруулсан/ Prepared by:	Төлөөлөн удирдах зөвлөл
Баталсан/ Approved by:	“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл
Хуудасны тоо/ Page number:	... хуудас
Хянан нийцүүлэх давтамж:	Жилд 1 удаа
Батлагдсан огноо/ Effective date:	2026 оны ... сарын ...

АГУУЛГА

Гарчиг

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
2. ЗОРИЛГО	4
3. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	4
4. МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ.....	5
5. МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ, ЗОРИУЛАЛТ	5
6. МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ	7
7. МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ ХЭРЭГСЭЛ, ХУГАЦАА.....	8
8. ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	8
9. ХАРИУЦЛАГА, САЙЖРУУЛАЛТ	9

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам (цаашид “журам” гэх)-аар Соломон Инвестмент ББСБ ХХК (цаашид “ББСБ” гэх)-ийн мэдээллийн нууцлал, мэдээллийг боловсруулах, нийтэд мэдээлэх, тайлагнах, мэдээлэлд зөрүү гарсан тохиолдолд түүнийг залруулах ажиллагааг зохицуулна.
- 1.2. Журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 1.3. ББСБ нь үйл ажиллагаандаа Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ББСБ-ын засаглалын кодексыг дагаж мөрдөнө.
- 1.4. ББСБ нь мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгоно. Үүнд:
 - 1.4.1. Тухайн мэдээллийн ач холбогдох, ББСБ-ын бизнест нөлөөлөх байдлаас хамааруулан мэдээллийг тогтмол давтамжтай боловсруулах, шинэчлэх;
 - 1.4.2. Хууль тогтоомж, дүрэм журамд заасан болон мэдээллийг нийтэд хүргэх шаардлага, ач холбогдолтой нь уялдуулан тогтсон цаг хугацаанд нь олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагад хүргэх;
 - 1.4.3. ББСБ-ын хувьцаа эзэмшигчид болон оролцогч бусад этгээдэд тэгш хүртээмжтэй байх;
 - 1.4.4. Үнэн зөв, тодорхой, ойлгомжтой, бүрэн хэмжээтэй байх;
 - 1.4.5. ББСБ-ын бизнесийн эрх, ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх

2. ЗОРИЛГО

- 2.1. ББСБ нь ББСБ-ын мэдээлэл болон өгөгдлийг тэдгээрийн эмзэг байдал, үнэ цэн, чухал байдалд нь тулгуурлан ангилж, ангиллын дагуу мэдээлэлд хандах эрхийг тодорхойлох бөгөөд хууль, тогтоомж, ББСБ-ын засаглалын кодексст заасан мэдээллийг ил тод нээлттэй байлгахад энэхүү журмын зорилго оршино.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 3.1. Дараах нь энэхүү баримт бичигт дурдагдах нэр томьёо болон товчилсон үгийн тайлбар болно.

Мэдээлэл	Утга бүхий өгөгдлийг (биет, хэвлэмэл, файлаар, электрон хэлбэрээр эсвэл өгөгдлийн санд байгаа баримт бичиг эсвэл өгөгдөл);
Биет буюу физик түвшний халдлага	Мэдээллийн сан байрлах физик дэд бүтцэд зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг;
Мэдээллийн сан	Энэхүү журмаар зохицуулагдах хуульд заасан мэдээллийн нэгдсэн ангилал код, индекс, арга зүй, стандартаар ижилтгэсэн баримт бичгийг шаардлагын

	дагуу цуглуулж, боловсруулж хадгалсан мэдээлэл, өгөгдлийн бүрдлийг
Нягтаршуулж байрлуулах	Их хэмжээтэй цахим мэдээллийн сангийн багтаамжийг шахаж бага хэмжээтэй болгож байрлуулахыг
Татаж авах боломжтой	Цахим хуудсан дахь мэдээллийг байршил, цаг хугацаа хамаарахгүйгээр тухайн тооцоолуурт (компьютер, хөдөлгөөнт холбооны бусад төхөөрөмжүүд) хадгалахыг;
Устгах	Цахим мэдээлэл, өгөгдлийг мэдээллийн сангаас дахин ашиглах боломжгүйгээр арилгахыг;
Цахим мэдээллийн архив бүртгэлийн автоматжуулсан систем	Компьютер дээр тусгай зориулалтын бүртгэлийн программд оруулсан өгөгдөл, мэдээлэлд хандах, засварлах, нэмэх ажиллагааг хялбаршуулсан системийг
Цахим бичиг баримтын мэдээллийн анхдагч байдал	Мэдээллийн санд цахим бичиг баримтыг боловсруулахдаа засвар, өөрчлөлт оруулаагүй анхдагч хувилбарыг
Цахим хэлбэрт оруулах	Цаасан суурьтай мэдээлэл, өгөгдлийг компьютерт хөрвүүлж цахим баримт бичиг үүсгэхийг.

4. МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ

- 4.1. ББСБ нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах үйл ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах бөгөөд хууль, тогтоомж болон энэхүү журамд заасан үндэслэлээр нийтэд эсхүл гуравдагч этгээдэд мэдээллийг дамжуулна. Үүнд:
- 4.1.1. Хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагчтай харилцах, ББСБ-ын үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээлэл;
- 4.1.2. Хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгө оруулалтын дүн,
- 4.1.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журамд заасан сэжигтэй үйлдлийг илрүүлэх зорилгоор цуглуулах мэдээлэл;
- 4.1.4. Үйл ажиллагааны хүрээнд олж авсан аливаа нийтэд ил болоогүй мэдээлэл;

5. МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ, ЗОРИУЛАЛТ

- 5.1. ББСБ-аас боловсруулан гаргаж буй мэдээлэлд ББСБ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, санхүүгийн тайлан болон хөрөнгө оруулагчид эсвэл бусад этгээд мэдвэл зохих бусад мэдээллүүд багтана.
- 5.2. ББСБ-аас боловсруулан гаргаж буй мэдээллүүдийг түүний зориулалт, нууцлалын шаардлага зэргийг харгалзан дараах үндсэн ангилалд хуваана. Үүнд:
- 5.2.1. Нийтэд нээлттэй мэдээлэл (1-р зэрэглэл);
- 5.2.2. Дотоодод нээлттэй мэдээлэл (2-р зэрэглэл);
- 5.2.3. Нууц мэдээлэл (3-р зэрэглэл)

- 5.3. Нийтэд нээлттэй мэдээлэлд ББСБ-ын жилийн үйл ажиллагааны тайлан мэдээллүүд буюу дараах мэдээллүүд багтана. Үүнд:
- 5.3.1. ББСБ-ын зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;
 - 5.3.2. ББСБ-ын Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл;
 - 5.3.3. ББСБ-ын удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
 - 5.3.4. ББСБ-ын засаглалын кодексыг хэрэгжүүлсэн талаарх тайлан;
 - 5.3.5. Хорооноос баталсан ББСБ-ын засаглалын кодекс тухай бүр нээлттэй мэдээлэхээр тусгасан мэдээлэл;
- 5.4. Дотоодод нээлттэй мэдээлэл гэж хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн байдал, эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр олон нийтэд хүргэх нь зүйтэй хэмээн үзсэн ББСБ-ын үйл ажиллагаа, хувьцааны үнэ ханшид нөлөөлөх боломжтой мэдээллүүд орно. Үүнд:
- 5.4.1. ББСБ-ын үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлд нь зогсоосон;
 - 5.4.2. ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсэж болох эрсдэлийн тухай мэдээлэл;
 - 5.4.3. ББСБ-ын тухайн салбарт эзэлж буй байр суурь;
 - 5.4.4. ББСБ-ын ТУЗ, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл;
 - 5.4.5. ББСБ-ын оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой ББСБ-ын оршин байх хаяг өөрчлөгдсөн;
 - 5.4.6. Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах тухай мэдээлэл;
 - 5.4.7. ББСБ-ын ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
 - 5.4.8. Гүйцэтгэх удирдлагын баг, эрх бүхий албан тушаалтны 20 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;
 - 5.4.9. ББСБ-ын нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтэц өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
 - 5.4.10. ББСБ-ын ТУЗ-ийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
 - 5.4.11. Бусад мэдээлэл.
- 5.5. Нууц мэдээлэл гэж байгууллагад хамгийн эмзэг бөгөөд нууц мэдээлэл байх ба зөвшөөрөлгүй хуваалцах, ил болгох нь байгууллагад санхүүгийн эсвэл үйл ажиллагааны томоохон хохирол авчирна. "Нууц" ангиллын мэдээллийг задруулах эсвэл өөрчлөх нь гэрээний, эрх бүхий байгууллага болон хуулийн үл нийцэлд хүргэх дараах мэдээллүүд орно. Үүнд:
- 5.5.1. ББСБ-ын ТУЗ, хувьцаа эзэмшигчийн шийдвэр, тогтоол болон холбогдох бусад мэдээлэл;

- 5.5.2. ББСБ-ын санхүүгийн тайлан болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээлэл;
 - 5.5.3. ББСБ-ын ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын мэдээлэл;
 - 5.5.4. ББСБ-ын хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;
 - 5.5.5. Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх;
 - 5.5.6. Бусад ББСБ-ын хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдан авах, худалдах;
 - 5.5.7. ББСБ-ын хөрөнгө, өр төлбөр, үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ, хэлцэл байгуулах;
 - 5.5.8. ББСБ-ын нийт хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;
 - 5.5.9. ББСБ-ын хөндлөнгийн аудитын байгууллагатай байгуулсан гэрээ, түүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
 - 5.5.10. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулсан тухай мэдээлэл;
 - 5.5.11. ББСБ-ын гаргасан нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
 - 5.5.12. Компани өр төлбөрөө эргэн төлөх санхүүгийн чадваргүй болсон тухай мэдээлэл;
 - 5.5.13. Компанийг татан буулгах тухай шийдвэр;
 - 5.5.14. ББСБ-ын нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой гэмт үйлдэл хийсэн нь тогтоогдсон тухай мэдээлэл;
 - 5.5.15. Нууц гэж тодорхойлсон бусад мэдээлэл.
- 5.6. Энэхүү журмын 5.4-т заасан мэдээллийг олон нийтэд мэдээлэх эсэх, хэрэв мэдээлэхээр тогтоосон бол түүний хугацаа, арга замыг ББСБ-ын ТУЗ тогтоох ба Гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийн хүрээнд мэдээлэх мэдээллүүдийг Гүйцэтгэх захирлын зөвшөөрөлтэйгөөр нийтэд мэдээллэнэ.
 - 5.7. Хуулиар хамгаалагдсан аливаа мэдээллийг нууц мэдээлэл гэх ба тус мэдээллийг шүүх, цагдаа, татвар, хянан шалгагч зэрэг эрх бүхий этгээдээс хууль тогтоомжид заасан үндэслэлээр шаардсанаас бусад тохиолдолд мэдээлэхгүй.

6. МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

- 6.1. Нийтэд нээлттэй ба дотоодод нээлттэй түгээх мэдээллийг ТУЗ болон ББСБ-ын тухай асуудлаар харьяалсан чиг үүрэг бүхий албан тушаалтан, алба, нэгжийн захирал хариуцан гаргаж Гүйцэтгэх удирдлагад болон Гүйцэтгэх удирдлагын томилсон мэдээллийг олон нийтэд түгээх эрх бүхий албан тушаалтанд шуурхай хүргэнэ.
- 6.2. Мэдээллийн үнэн бодит байдлыг мэдээлэл гаргасан нэгжийн захирал болон Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлаас эрх олгогдсоны дагуу мэдээллийг

түгээсэн ажилтан хариуцах бөгөөд ББСБ-ын дотоод хяналт хариуцсан нэгж, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо хяналт тавина.

- 6.3. ББСБ-ын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, комплайнсын ажилтан нь энэхүү журмын 5 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг тухай бүр холбогдох эрх бүхий байгууллагад болон өөрийн цахим хуудас болон бусад боломжит сувгаар дамжуулан нийтэд түгээх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 6.4. Мэдээлэл боловсруулагч болон олж авсан ажилтан, хувь хүн нь мэдээллийг энэхүү журамд заасан нөхцөл, хугацаагаар нийтэд мэдээлэх хүртэл мэдээллийн нууцлалыг хариуцан ажиллах үүрэгтэй.

7. МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ ХЭРЭГСЭЛ, ХУГАЦАА

- 7.1. Мэдээллийг холбогдох нэгж буюу нэгжийн хамтын ажиллагааны үндсэн дээр үнэн зөв эх сурвалжуудыг ашиглан боловсруулах ба ББСБ-ын цахим хуудас, Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагын цахим хуудас, холбоо харилцааны хэрэгслүүд, биечилсэн уулзалт, олон нийтийн мэдээллийн сувгуудын нэгийг буюу хэсгийг ашиглан хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хүргэнэ.
- 7.2. ББСБ нь жилийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүр өөрийн цахим хуудсанд байршуулна.
- 7.3. Нийтэд нээлттэй мэдээллүүдийг ББСБ-ын цахим хуудсанд байршуулсан хугацаанаас хойш 5 жил хадгалах боломжтойгоор программ хангамжийг тохируулсан байна.
- 7.4. Нийтэд нээлттэй түгээсэн мэдээллүүдийн эх хувь, цаасан болон цахим баримтуудыг ББСБ-ын Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу бүртгэж хадгална.

8. ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 8.1. Дараах этгээдийг ББСБ-ын дотоод мэдээлэл эзэмшигч гэж үзнэ. Үүнд:
 - 8.1.1. ББСБ-ын нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд буюу хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон үйл ажиллагаа хариуцсан захирлууд,
 - 8.1.2. Албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд буюу газар нэгжийн ахлах мэргэжилтэн, нягтлан бодогч, хөрөнгө оруулалтын зөвлөхүүдийг тус тус ойлгоно.
- 8.2. Энэхүү журмын 8.1-т заасан дотоод мэдээлэл эзэмшигчдэд дараах зүйлийг хориглоно. Үүнд:
 - 8.2.1. Уг мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамран Гүйцэтгэх удирдлага болон шууд удирдлагын зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэл цацах, алдаатай, буруу, ташаа, худал мэдээлэл цацах;
 - 8.2.2. Албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах.

8.3. Мэдээлэл эзэмшигч нь дараах үндэслэлээр мэдээллийг устгах, эсвэл өөрчлөлт оруулна. Үүнд:

8.3.1. Тухайн мэдээллийг хууль болон журамд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглаагүй бол эрх бүхий албан тушаалтны санаачилгаар;

8.3.2. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр мэдээллийг устгахаар мэдээлэл хариуцагч үүрэг хүлээсэн.

9. ХАРИУЦЛАГА, САЙЖРУУЛАЛТ

9.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн, захиргааны, зөрчлийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүнд ББСБ-ын "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ ногдуулна.

9.2. Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл нь ББСБ-ын нэр хүнд, хөрөнгө, үйл ажиллагаанд хохирол учруулсан бол түүнд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцуулна.

9.3. ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь ББСБ-ын жилийн үйл ажиллагааны мэдээлэл, тайлагналтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомж, ББСБ-ын засаглалын кодекст нийцэж буй байдалд хяналт тавих, бодлого журамд сайжруулалт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ТУЗ нэмэлт өөрчлөлт оруулж болно.

--ooOoo--